



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/250

Хэрлэн сум

Сургалт арга хэмжээнд  
хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 2020 оны 2 дугаар хуралдааны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулах зорилтын хүрээнд, “Цахим аймаг” бодлогын зөвлөмж болон иргэдийн оролцоот Хэтийн Хэнтий арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын дагуу, Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас улс орон даяар өрнүүлж буй “DIGITAL FIRST-D1” арга хэмжээнд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн байгууллагын цахим үйлчилгээний түргэн шуурхай, ил тод байдлыг хангах, иргэн, хуулийн этгээдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх сургалт арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах заал, танхим, техник хэрэгслээр хангах зардалд 4,346,180 (дөрвөн сая гурван зуун дөчин зургаан мянга нэг зуун наяд) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Арга хэмжээний зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Энэхүү зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрч, Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Даймгийн Засаг даргын 2024 оны  
дугаар сарын 09-ны өдрийн  
дугаар захирамжийн хавсралт

**ХЭНТИЙ "DIGITAL FIRST - D1"  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ**

2024 оны 04 дугаар сарын 10

д/д	Зардалын нэр	Хэмжих нэгж	Зориулалт	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Сургалтын заал танхим, техник хэрэгсэл		ЖДҮ, бизнес эрхлэгчдэд технологийн дэвшлийг танилцуулах сургалт, экспо	-	1.864.000
2	Баннер	3,80x3,0	Дотор танхим орчинд	-	228.000
3	QR хэвлэл	1ш	Дотор танхим орчинд	48000	48.000
4	Сургалтын материал, гарын авлага	50ш	Гар зургийн архив үүсгэх	5220	261.000
5	Сургалтад оролцогчдын цайлах зардал	140 хүн	Мэдээллийн технологийн ажилтнууд, бизнес эрхлэгчид, speed date арга хэмжээнд оролцогчдын цай	13400	1.876.700
6	Ус /0,5/	64ш	Илтгэгч, зочдод	1070	68.480
Нийт дүн:					4.346.180

\_\_\_оОо\_\_\_